

I. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үндэсний статистикийн хорооны 2022 оны байдлаар Монгол Улсад 15 ба түүнээс дээш хөдөлмөрийн насны 2,159.6 мянган хүн байгаагийн 1,265.2 мянга нь ажиллах хүч, 894.3 мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

Хүснэгт 1: Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлт¹

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022	2023 /3-р сар/
15 ба түүнээс дээш насны хүн ам /мян.хүн/	2,220.4	2,226.5	2,106.0	2,128.1	2,152.1	2,159.6	2,159.6
Ажиллах хүч /мян.хүн/	1,357.4	1,358.6	1,273.9	1,250.6	1,225.4	1,265.2	1,265.2
Ажиллагчид /мян.хүн/	1,238.4	1,253.0	1,146.1	1,162.9	1,125.6	1,180.4	1,180.4
Ажилгүй иргэд /мян.хүн/	119	105.6	127.7	87.7	99.8	84.7	84.7
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам /мян.хүн/	863	867.9	832.1	877.5	926.7	894.3	894.3
Ажил хайгч иргэний тоо /мян.хүн/	37.1	36.2	37	30	28	21.2	8,4
Бүртгэлтэй ажилгүй иргэд /мян.хүн/	25.5	25	20.7	18.1	18.6	13.9	6,2
Ажиллах хүчний оролцооны түвшин /хувь/	61.1	61	60.5	58.8	58.3	58.6	58.6
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /хувь/	55.8	56.3	54.4	54.6	53.6	54.7	54.7
Ажилгүйдлийн түвшин /хувь/	8.8	7.8	7.8	7	8.1	6.7	6.7
Ядуурлын түвшин /хувь/	-	28.4	-	27.8	-	-	-
Ажлын байрны захиалгын тоо	62,574	64,478	71124	58,022	51,034	55,211	10,308
Ажилд зуучлагдсан иргэний тоо	45,683	43,105	44059	33,006	29,929	32,290	2,371
Шинэ ажлын байранд орсон иргэний тоо	27,284	27,146	33,325	31,800	28,390	27,390	1,559
Гадаадад ажиллах хүч илгээх үйлчилгээ авсан иргэний тоо	36,574	58,078	92,517	30,498	49,449	35,769	3776
Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж буй гадаадын ажиллах хүч, мэргэжилтний тоо	4,703	4,502	4,601	5,058	4,039	3,943	5740
БНСУ-д ажиллахаар хил нэвтэрсэн иргэдийн тоо	1,058	784	633	63	176	863	188
Япон Улсад ажиллахаар хил нэвтэрсэн иргэдийн тоо	-	-	-	-	12	94	28

¹ www.1212.mn

Хүснэгт 2: Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний үндсэн үзүүлэлтийн мэдээлэл²

№	Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар	2017	2018	2019	2020	2021	2022
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	356,423	334,101	290,160	276,455	277,783	290,797
2	Уул уурхай, олборлолт	52,017	57,687	57,923	51,575	56,226	62,750
3	Боловсруулах үйлдвэрлэл	93,062	100,805	90,378	89,722	81,630	106,174
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	17,458	16,307	19,348	14,380	16,775	18,465
5	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	4,864	6,869	10,786	8,314	5,894	7,894
6	Барилга	70,604	76,596	68,847	77,279	80,866	62,484
7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	204,474	211,187	160,405	166,590	143,466	148,702
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	72,702	73,567	61,123	66,541	67,193	71,446
9	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	36,449	37,484	36,280	29,991	34,537	29,776
10	Мэдээлэл, холбоо	14,490	14,089	13,019	18,830	18,956	19,088
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	24,120	25,689	24,257	29,355	29,158	23,901
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	379	770	1,154	3,411	2,580	-
13	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	12,743	14,608	18,031	11,612	17,152	15,336
14	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	20,832	18,185	20,163	18,050	12,960	11,155
15	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	82,236	76,197	85,965	83,369	90,422	91,720
16	Боловсрол	98,876	98,738	96,108	110,735	111,299	104,872
17	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	39,973	49,462	44,376	60,189	47,133	49,300
18	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	10,104	13,835	17,999	10,812	6,350	10,904
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	22,728	23,364	24,547	29,752	24,096	31,569
20	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	2,294	1,226	3,275	3,292	2,635	320.1
21	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1,505	2,256	2,014	2,641	-	1,595
Бүгд		1,238,333	1,253,023	1,146,161	1,162,912	1,127,111	1,158,245

² www.1212.mn

Хүснэгт 3: Ажиллах хүчнээс гадуурх хүн ам³

№	Ажилгүй байгаа шалтгаан	2021 он			2022 он		
		Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Дүн		878156	336655	541502	888140	348380	539760
1	Хөдөлмөрийн нас хүрээгүй	783	0	783	620	244	376
2	Суралцдаг	232717	108642	124075	243978	125862	118116
3	Тэтгэвэрт гарсан	344453	125729	218724	329634	117472	212162
4	Өвчтэй	24201	15329	8872	41729	20879	20850
5	Хөгжлийн бэрхшээлтэй	46011	23562	22449	35976	22041	13935
6	Жирэмсэн/хүүхэд асарсан	111662	4466	107197	123159	2798	120361
7	Бусдыг асарсан	20710	5166	15544	16879	7953	8926
8	Тухайн жилд цэргээс халагдсан	354	354	0	54.3	54.3	0
9	Тухайн жилд сургууль төгссөн	2567	812	1756	2526	911	1615
10	Шилжин суурьшсан	0	0	0	38	38	0
11	Аав, ээж, гэр бүл, үр хүүхдээ дагаад	2992	609	2383	7204	3028	4176
12	Хүүхдээ сургуульд сургахаар	6446	774	5672	15409	2488	12922
13	Гадаадад амьдарч байгаад ирсэн	655	0	655	1639	656	983
14	Засан хүмүүжүүлэх газраас суллагдсан	0	0	0	0	0	0
15	Байгууллага татан буугдсан	3908	3418	490	0	0	0
16	Цомхотголд орсон	2593	1892	700	2364	1909	455
17	Улирлын чанартай ажил хийдэг болохоор	9786	8930	857	11459	9124	2335
18	Мэргэжил, дадлага туршлага байхгүй	5738	3438	2299	7256	4145	3111
19	Мэргэжилд тохирох ажил олдохгүй	4071	387	3684	3718	2519	1199
20	Ажил хайгаад олдохгүй байгаа	11447	7078	4368	8137	4158	3979
21	Байгалийн гамшиг, аюулт үзэгдэлд өртөж малгүй болсон (ган, зуд, үе)	0	0	0	0	0	0
22	Ажиллах сонирхолгүй байсан	2337	653	1684	3329	2016	1312
23	Цалин бага учраас	1550	426	1125	2074	1474	600
24	Малчин	13401	7483	5918	16198	10143	6054
25	Цар тахлын улмаас	14095	7415	6680	3054	1973	1082
26	Бусад	15679	10092	5587	11707	6495	5212

³ www.1212.mn

II. АЖИЛ ХАЙГЧ БОЛОН БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН

Ажил хайгч: 2023 оны 3 дугаар сарын байдлаар аймаг, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд ажил идэвхтэй хайж буй ажил хайгч иргэдийн тоо **8439** болж өмнөх сараас 951 хүнээр буюу 12.7 пунктээр өссөн ба өмнөх оны мөн үеэс **15816** хүнээр буюу 65.2 пунктээр буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэд: 2023 оны 3 дугаар сарын байдлаар аймаг, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо **6241** болж өмнөх сараас 746 хүнээр 13.6 пунктээр өссөн ба өмнөх оны мөн үеэс **10421** хүнээр буюу 62.5 пунктээр буурсан байна.


Хүснэгт 4: Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэдийг байршилаар харуулвал

№	Аймаг, бүсээр	Ажил хайгч	Үүнээс эмэгтэй	Бүртгэлтэй ажилгүй иргэн	Үүнээс эмэгтэй
Баруун бүс		2671	1257	2160	1020
1	Баян-Өлгий	812	372	789	360
2	Говь-Алтай	330	153	283	129
3	Завхан	99	52	84	41
4	Увс	386	184	335	155
5	Ховд	1044	496	669	335
Хангайн бүс		1275	700	865	494
6	Архангай	218	124	91	45
7	Баянхонгор	400	249	343	212
8	Булган	162	78	113	52
9	Орхон	165	108	146	94
10	Өвөрхангай	196	70	66	39
11	Хөвсгөл	134	71	106	52
Төвийн бүс		1315	664	936	458
12	Говьсүмбэр	7	4	2	1
13	Дархан-Уул	301	161	157	77
14	Дорноговь	134	65	117	57
15	Дундговь	189	88	161	81
16	Өмнөговь	249	136	169	91
17	Сэлэнгэ	235	116	184	86
18	Төв	200	94	146	65
Зүүн бүс		981	469	776	356
19	Дорнод	430	164	329	121
20	Сүхбаатар	180	74	135	47
21	Хэнтий	371	231	312	188
Улаанбаатар		2197	1167	1504	791
22	Хан-Уул	42	21	27	16



23	Багануур	86	52	75	44
24	Баянзүрх	223	129	172	101
25	Налайх	50	20	32	12
26	Баянгол	185	100	146	79
27	Сүхбаатар	296	158	260	131
28	Чингэлтэй	178	103	125	74
29	Багахангай	189	97	100	56
30	Сонгинохайрхан	948	487	567	278
УЛСЫН ДҮН		8439	4257	6241	3119

Нийт ажил хайгч иргэдийн 2671 буюу 31.7 хувь нь Баруун бүсэд, 1275 буюу 15.1 хувь нь Хангайн бүсэд, 1315 буюу 15.6 хувь нь Төвийн бүсэд, 981 буюу 11.6 хувь нь Зүүн бүсэд, 2197 буюу 26.0 хувь нь Улаанбаатарт байна.


Ажил хайгч иргэд: бүсээр, хүйсээр



Ажил хайгч иргэдийг насны бүлгээр авч үзвэл 16.0 хувь буюу 1352 нь 15-24 насны, 35.4 хувь буюу 2990 нь 25-34 насны, 27.3 хувь буюу 2308 нь 35-44 насны, 16.1 хувь буюу 1361 нь 45-54 насны, 3.4 хувь буюу 285 нь 55-59 насны, 1.7 хувь буюу 143 нь 60-аас дээш насныхан эзэлж байна.




Ажил хайгч иргэдийг боловсролоор: Нийт ажил хайгч иргэдийн 254 буюу 1,8 хувь нь магистр, доктор, 4158 буюу 29,2 хувь нь дипломын дээд болон бакалаврын, 721 буюу 5,1 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 1430 буюу 10,0 хувь нь техникийн болон мэргэжлийн, 6159 буюу 43,2 хувь нь бүрэн дунд, 876 буюу 6,1 хувь нь суурь, 454 буюу 3,2 хувь нь бага, 194 буюу 1,4 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна.



Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 2160 буюу 34.6 хувь нь Баруун бүсэд, 865 буюу 13.9 хувь нь Хангайн бүсэд, 936 буюу 15.0 хувь нь Төвийн бүсэд, 776 буюу 12.4 хувь нь Зүүн бүсэд, 1504 буюу 24.1 хувь нь Улаанбаатарт байна.




Бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзвэл 16.6 хувь буюу 1038 нь 15-24 насны, 36.8 хувь буюу 2298 нь 25-34 насны, 26.6 хувь буюу 1663 нь 35-44 насны, 15.0 хувь буюу 938 нь 45-54 насны 3.3 хувь буюу 208 нь 55-59 насны, 1.5 хувь буюу 96 нь 60-аас дээш насныхан эзэлж байна.



Бүртгэлтэй ажилгүй иргэд: боловсролоор: Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 102 буюу 1.6 хувь нь магистр, доктор, 1785 буюу 28.6 хувь нь дипломын болон баклаврын, 351 буюу 5.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 822 буюу 13.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 2390 буюу 38.3 хувь нь бүрэн дунд, 462 буюу 7.4 хувь нь суурь, 238 буюу 7.4 хувь нь бага, 91 буюу 1.5 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 3119 буюу 50.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.




III. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Ажлын байрны захиалга: Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын сул байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажиллахад бэлэн ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй ажилгүй иргэдээр тооцож байгаа ба ажлын байрны хомсдолоос шалтгаалан эрэлт, нийлүүлэлтийн харьцаа харилцан адилгүй байна.

Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын ашиглалт аймаг, нийслэлд ялгаатай байна. Тухайлбал аймгийн дунджаар 49 хувьтай байхад нийслэлд 70 хувьтай байна. Улсын хэмжээнд ажлын байрны ашиглалт 54 хувьтай байна.


Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй иргэдээр тооцов.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг сүүлийн 3 жилээр харуулвал:



2023 оны 3 дугаар сард ажил олгогчдоос нийт **10308** ажлын байрны захиалга ирүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга 986 буюу 10.6 хувиар өссөн байна.

Ажлын байрны захиалгыг байршилаар



Хүснэгт 6: Ажлын байрны захиалгыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

№	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын тоо	Эзлэх хувь /%/
1	Хөдөө аж ахуй, загас барилт, ан агнуур	357	3.5
2	Уул уурхай олборлолт	1005	9.7
3	Боловсруулах үйлдвэр	1309	12.7
4	Цахилгаан, хий, уур агааржуулалт	600	5.8
5	Усны хангамж бохир ус зайлуулах систем хог хаягдал	61	0.6
6	Барилга	1250	12.1
7	Бөөний ба жижиглэнгийн худалдаа үйлчилгээ	2049	19.9
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	123	1.2
9	Зочид буудал, зоогийн газар	294	2.9
10	Мэдээлэл холбоо	79	0.8
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	156	1.5
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	19	0.2
13	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	154	1.5
14	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	244	2.4
15	Төрийн удирдлага болон батлан хамгаалах үйл ажиллагаа	996	9.7
16	Боловсрол	942	9.1
17	Эрүүл мэнд, нийгмийн халамж	402	3.9
18	Урлаг үзвэр тоглоом наадам	74	0.7
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	162	1.6
20	Хүн хөлслөн ажиллуулдаг, өрхийн аж ахуй	22	0.2
21	Олон улсын байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	10	0.1
ДҮН		10308	100


Хүснэгт 7: Ажлын байрны захиалгыг ажил мэргэжлийн ангиллаар

№	Ажил мэргэжлийн ангилал	Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын тоо	Эзлэх хувь /%/
1	Менежер	472	4.6
2	Мэргэжилтэн	2882	28.0
3	Техникч болон туслах /дэд мэргэжилтэн/	652	6.3
4	Контор үйлчилгээний ажилтан	343	3.3
5	Худалдаа үйлчилгээний ажилтан	1572	15.3
6	ХАА, загас ан агнуурын ажилтан	51	0.5
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	1715	16.6
8	Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	863	8.4
9	Энгийн ажил, мэргэжил	144	1.4
10	Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	1614	15.7
ДҮН		10308	100


Ажилд зуучлах үйлчилгээ: 2023 оны 3 дугаар сарын байдлаар ажил олгогчдоос нийт **10308** ажлын байрны захиалга ирүүлсэнээс **2371** иргэнийг эдгээр ажлын байранд ажилд зуучлан оруулсан байна. Энэ нь ажлын байрны ашиглалт 23 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилд зуучлан оруулсан хүний тоо 1530 хүнээр буюу 39.2 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.




Нийт ажилд зуучлагдан орсон иргэдийг байршил, хүйсээр харуулбал:



Нийт ажилд зуучлагдан орсон иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл:



Ажилд зуучлагдан орсон иргэдийг насны бүлэг, хүйсээр авч үзвэл:



Ажлын шинэ байр: Улсын хэмжээнд 2023 оны 3 дугаар сард нийт **912** ажлын шинэ байр бий болж, түүнд ажилгүй иргэдийг бүрэн байршуулсан байна. Тайлант хугацаанд нийт **912** ажлын шинэ байрыг бүртгэж тухайн ажлын байранд ажилд орсон иргэдийн мэдээллээр баталгаажуулсан байна. Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл **1952** хүнээр буюу **68.1** хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Нийт шинэ ажлын байрнаас байнгын шинэ ажлын байр 1367 буюу 87.7 хувь, улирлын шинэ ажлын байр 125 буюу 8.0 хувь, түр шинэ ажлын байр 67 буюу 4.3 хувийг тус тус эзэлж байна.

IV. ХӨДӨЛМӨРИЙН ХУВИЙН БИРЖИЙН ТАЙЛАН

Хөдөлмөрийн биржийн сарын мэдээ тайланг шалгаж, санхүүжилт олгох үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд хөдөлмөрийн хувийн биржээр дамжуулан үзүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг 2023 оны 2 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр авч үзвэл:

- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгсөн: 597
- Бүлгийн зөвлөгөө өгсөн: 210 бүлэг
- Ажилд зуучилсан хүний тоо: 58
- 3 сар тогтвортой ажилласан иргэн: 60
- 6 сар тогтвортой ажилласан иргэн: 41
- 12 сар тогтвортой ажилласан иргэн: 56

Нийт олгосон санхүүжилт: 82,851,575 төгрөг зарцуулсан байна.